



Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын
2010 оны 331 дугаар тушаалын хавсралт

РЕГИСТРИЙН ДУГААРЫГ ШИНЭЭР ОЛГОХ, ЁЁРЧЛӨХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Регистрийн дугаарыг шинээр олгох, олгогдсон дугаарыг ёерчилж дахин олгох, хүчингүй болгоход энэхүү журмыг мөрдөнө.

1.2. "Регистрийн дугаар" нь иргэний улсын бйртгэлд бйртгэгдсэн Монгол Улсын иргэнийг нэгэн утгатай тодорхойлсон ёсэг, тооноос бйтсэн нийлмэл код байна.

Регистрийн дугаарын эхний 2 орон буюу ёсэг нь регистрийн дугаар авч байгаа иргэний байнга оршин суудаг аймаг /дййрэг/, сум /хороо/-ны код, дараагийн 6 орон нь төрсөн он, сар, ёдөр 9 дэх орон нь хййс, сйлийн нэг орон нь хяналтын код байна.

Регистрийн дугаарын хяналтын код нь уг дугаарт орж байгаа хоёр ёсэг, эхний 7 цифрийн аль нэгийг ёерчлөх, санамсаргйй алдахаас хамгаална.

1.3. Монгол Улсын иргэн хйчин тегелдөр зөвхөн нэг регистрийн дугаартай байна.

1.4. Регистрийн дугаар нь Иргэний бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2-т зааснаар иргэний иргэний інэмлэх, тїїнийг орлох баримт бичиг, энгийн гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг, иргэний улсын бүртгэлийн гэрчилгээ, хадгаламж, бїх төрлийн даатгалын дэвтэр, жолоодох эрхийн інэмлэх болон эд хөрөнгө эзэмших эрхтэй холбоотой /орон сууц хувьчилж авсан гэрчилгээ зэрэг/ баримт бичигт бичигдэж тїїний хїчинтэй байдлыг хангана.

Хоёр. Регистрийн дугаарыг шинээр олгох

2.1. Шинэ төрсөн хїїхдэд регистрийн дугаарыг сум, дїїргийн улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгжийн ажилтан, улсын бүртгэгч олгоно.

2.2. Регистрийн дугаарыг дараах тохиолдолд шинээр олгоно.їїнд:

2.2.1. шинээр төрсөн хїїхэд;

2.2.2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын харьяат болсон иргэн;

2.2.3. регистрийн дугаар авч байгаагүй иргэн.

2.3. Энэ журмын 2.2.1-т зааснаас бусад тохиолдолд регистрийн дугаар шинээр авах иргэн дараах материалыг бїрдїїлж, бүртгэлийн байгууллагад биечлэн ирнэ.

2.3.1. 16 хїртэлх насны хїїхэд:

2.3.1.1. төрсний гэрчилгээ эсхїл төрж шинээр бїртгїїлж байгаа бол эрүүл мэндийн дэвтэр;

2.3.1.2. эцэг, эхийн иргэний інэмлэх.

2.3.2. 16 -аас дээш насны иргэн:

2.3.2.1. төрсний гэрчилгээ;

2.3.2.2. иргэний інэмлэх ;

2.3.2.3. гэрлэсний гэрчилгээ;

2.3.2.4. нехер, эхнэрийн иргэний інэмлэх;

2.3.2.5. хїїхдийн төрсний гэрчилгээ;

2.3.2.6. үндэсний энгийн гадаад паспорт, бусад нотлох иргэний баримт бичиг /гадаад улсад удаан хугацаагаар оршин сууж байсан иргэний хувьд/;

2.3.2.7. шїїхийн шийдвэр биелїлэх байгууллагын тодорхойлолт /ял эдэлж байгаад суллагдсан иргэний хувьд/;

2.3.2.8. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг /Монгол Улсын харъяат болсон иргэний хувьд/;

2.3.2.9. архивын эх нотлох баримтын лавлагаа /иргэний баримт бичиггїй, баримт бичгийн зерчлийн улмаас регистрийн дугаар аваагїй иргэний хувьд/;

2.3.2.10. оршин суугаа баг, хорооны Засаг даргын тодорхойлолт.

2.4. Регистрийн дугаар авч байгаагїй шалтгааны төрлөөс хамаарч иргэн энэ журмын 2.3.2 дах хэсэгт заасан баримт бичгийг бїрдїлэн нийслэлд Улсын бїртгэлийн ерөнхий газрын Иргэний бїртгэлийн газарт, орон нутагт аймгийн Улсын бїртгэлийн хэлтэст хандана.

Гэрэл, Регистрийн дугаарыг өөрчлөх даалгавар

3.1. Регистрийн дугаарыг дараах тохиолдолд өөрчилж дахин олгоно:

3.1.1. иргэний төрсөн он, сар, өдөр буюу насыг тогтоосон шїїхийн шийдвэр гарсан,

3.1.2. иргэний баримт бичиг дэх регистрийн дугаар архивын нотлох баримтаас зөрїтэй;

3.1.3. регистрийн дугаарыг буруу олгосон /регистрийн дугаарыг олгохдоо хүйс сольж олгосон, хийхдийн төрсний гэрчилгээний бүртгүүлсэн он, сар, өдрийг төрсөн он, сар, өдөр болгон сольж олгосон, баримт бичиг дээрх мэдээллээс зөрїтэй олгосон зэрэг/ ;

3.1.4. регистрийн дугаарыг давхардуулан олгосон.

3.2. Энэ журмын 3.1-д заасан үндэслэлээр регистрийн дугаарыг дахин авах иргэн дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

3.2.1. 16 хїртэлх насны хийхэд төрсний гэрчилгээ;

3.2.2. 16 ба тїїнээс дээш насны иргэн иргэний їнэмлэх, төрсний гэрчилгээ;

3.2.3. шїїхийн шийдвэрийн хуулбар;

3.2.4. иргэний баримтын архивын лавлагаа.

3.3. Регистрийн дугаарыг өөрчлїлж, дахин авах иргэн энэ журмын 3.2-т заасан баримт бичгийг бүрдүүлэн нийслэлд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний бүртгэлийн газарт, орон нутагт Улсын бүртгэлийн хэлтэст тус тус хандана.

3.4 Улсын бүртгэгч энэхїї журмын 3.1.1, 3.1.2 дахь хэсэгт заасан шалтгаанаар регистрийн дугаарыг өөрчилж, дахин олгохдоо иргэний гаргасан хїсэлт, холбогдох баримт бичгийг нийслэлд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бїртгэлийн хяналтын газарт, аймагт хяналтын улсын байцаагчид шилжїлнэ.

3.5. Регистрийн дугаар өөрчилж, дахин олгох асуудлаар гаргасан хяналтын улсын байцаагчийн дїгнэлтийг їндэслэн иргэний бїртгэл, мэдээллийн хэлтсийн регистрийн дугаарын өөрчлөлт хариуцсан улсын бїртгэгч, аймагт улсын бїртгэлийн хэлтсийн иргэний бїртгэлийн тасгийн улсын бїртгэгч регистрийн дугаарыг өөрчилж дахин олгох ажлыг тус тус гїйцэтгэнэ.

3.6. Журмын 3.1.3, 3.1.4 дэх хэсэгт заасан шалтгаанаар регистрийн дугаар өөрчилж, дахин олгох ажлыг нийслэлд Улсын бїртгэлийн ерөнхий газрын Иргэний бїртгэл, мэдээллийн хэлтсийн регистрийн дугаарын өөрчлөлт хариуцсан улсын бїртгэгч, аймагт улсын бїртгэлийн хэлтсийн иргэний бїртгэлийн тасгийн улсын бїртгэгч гїйцэтгэнэ.

3.7. Иргэний регистрийн дугаарыг шинээр олгоход Хїн амын регистрийн карт ХААТР-1 болон төрсний бүртгэлийн маягт /ИУБ-11/, регистрийн дугаарыг өөрчилж, дахин олгоход регистрийн дугаарыг өөрчилсөн тухай ХААТР-25 -ыг тус тус хөтөлж,

бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ.

Дөрөв. Регистрийн дугаарын бүртгэл

4.1. Регистрийн дугаар олгох дэвтрийг 5 жил тутамд эрэгтэй, эмэгтэй хүйс, аймаг, нийслэл, сум, дүүргийн ангилал, кодоор Мэдээлэл технологийн газраас математикийн аргачлалаар зохиож, улсын бүртгэлийн анхан шатны нэгжүүдэд хүргүүлнэ.

4.2. Регистрийн дугаар шинээр олгоход тухайн иргэний хүйс, төрсөн оныг үндэслэн “Регистрийн дугаар олголтын дэвтэр”-ийг сонгоно. Уг дэвтэр 1870-1899, 1900-1929, 1930-1959, 1960-1990, 1991 тийнээс хойш гэсэн оны дарааллаар тус бүр нь эрэгтэй, эмэгтэй буюу 2 тусгай дэвтэр нийлээд 10 дэвтэр байх бөгөөд тийнээс регистрийн дугаар авч байгаа иргэн хэдэн онд төрсөн, ямар хүйстэй гэдгээс хамаарч улсын бүртгэгч эрэгтэй, эмэгтэй регистрийн дугаарын дэвтрийг зөв сонгож олгоно.

4.3. Нэг сум, дүүргийн регистрийн дугаарын дэвтэр бүгд ижил үлдэгдэлтэй байна. Үлдэгдлийг дэвтрийн хуудасны зүүн дээд өнцөгт бичсэн байна. Хэрэв өөр үлдэгдэлтэй дэвтэр хиргүүлсэн бол улсын бүртгэгч Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний бүртгэлийн газарт мэдэгдэж, зөрчлийг арилгуулна.

4.4. “Регистрийн дугаар олгох дэвтэр”-ээс тухайн иргэний төрсөн /төрсөн оныг өөрчилсөн бол шинээр тогтоосон он/ оны хуудсыг олно. Нэг он 4 хуудастай байна.

4.5. Регистрийн дугаарын дэвтрийн багана нь төрсөн сарыг, мөр нь төрсөн өдрийг заах тул төрсөн сар, өдрийн огтлолцол дээрх 8 оронтой тоо нь уг хэний регистрийн дугаарын тоон хэсэг болно.

4.6. Төрсөн он, сар, өдөр нь адилхан иргэнд регистрийн дугаар давхардуулж олгохгүйн тулд регистрийн дугаар олголтын дэвтэрт олгогдсон регистрийн дугаарын доогуур зурж, төрсний бүртгэлийн дугаарыг бичиж, тэмдэглэнэ.

4.7. Регистрийн дугаарыг дараах иргэний баримт бичиг, иргэний улсын бүртгэлийн маягтын зориулалтын хэсэгт тэмдэглэнэ:

4.7.1. Төрсний гэрчилгээ;

4.7.2. Иргэний үнэмлэх олгох маягт /ИУБ-21/;

4.7.3. биеийн дөвхцахгүй өгөгдлийн бүртгэлийн маягт /ИУБ-31/;

4.7.4. иргэний үнэмлэх дахин авах өргөдөл, маягт

4.8. Регистрийн дугаар, иргэний овог, эцэг /эх/-ийн нэр, нэрийг иргэний баримт бичиг, мэдээний маягтад заавал дармалдаж бичнэ.

5. Регистрийн дугаар хүчингүй болгох

5.1. Иргэнд 1-ээс дээш регистрийн дугаар олгогдсон нөхцөлд иргэний баримтын архивын эх нотлох баримт, лавлагааг үндэслэн нэг регистрийн дугаарыг хүчинтэй үлдээж, бусад регистрийн дугаарыг хяналтын улсын ахлах байцаагчийн дүгнэлтээр хүчингүй болгоно.

5.2. Эцэг, эхийн хэн нэг нь Монгол Улсын харьяат, нөгөө нь гадаад улсын харьяат иргэний дундаас төрсөн Монгол Улсын харьяатаас гарахыг хүссэн 18 хүртэлх насны хүүхдэд олгосон регистрийн дугаарыг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын хүсэлтээр хяналтын улсын байцаагч дүгнэлт гаргаж, улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас хасалт хийнэ.

6. Регистрийн дугаарыг олгосон, еерчилсэн тухай

мэдээ тайлан гаргах журам

6.1. Шинээр терж бүртгүүлж байгаа хүүхдийн хувьд Төрсний бүртгэлийн маягт ИУБМ-11 бичиж, регистрийн дугаар олгон маягтыг Улсын бүртгэлийн ерөнхий газарт 14 хоногийн дотор ирүүлнэ.

6.2. Регистрийн дугаар аваагй иргэний тухайд “Монгол Улсын хйн амын регистрийн карт” /ХААТР-1/-ийг бичиж, регистрийн дугаар олгон маягыг 14 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт ирүүлнэ.

6.3. Регистрийн дугаар авсан боловч тэр нь буруу олгогдсон иргэний хувьд регистрийн дугаарыг зөв болгон шинэчилж олгох асуудлыг тухайн иргэний оршин суугаа аймаг, нийслэлийн улсын бүртгэлийн байгууллага шийдвэрлэж, иргэн бүрт “Регистрийн дугаар еерчилсэн тухай маягт” ХААТР-25-ыг бичиж, маягыг 14 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт ирүүлнэ.

6.4. Регистрийн дугаарыг олгосон, еерчилсэн, хүчингүй болгосон мэдээ тайланг аймаг, нийслэлийн улсын бүртгэлийн хэлтэс, газар сар бүр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний бүртгэл, мэдээллийн хэлтэст ирүүлж байна.

6.5. Тогтоосон хугацаанд мэдээ тайланг ирүүлээгй улсын бүртгэгчид зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хйлээлгэнэ.

7. Регистрийн дугаарын еерчлелтийн талаарх мэдээллийг цахим мэдээллийн сан, иргэний баримтын архивт тусгах

7.1. Иргэний улсын бүртгэлийн маягт хариуцсан улсын бүртгэгч хүлээн авсан ХААТР-25 маягыг нэг бйрчлэн бйртгэж, иргэний баримтын архивын санд шалгуулж, засвар, еерчлөлтийн бүртгэл хариуцсан улсын бүртгэгчээр улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд тусгуулна.

7.2. Иргэний бүртгэл, мэдээллийн хэлтсийн регистрийн дугаар, нөхөн бүртгэл, засвар, еерчлөлт хариуцсан улсын бүртгэгч дараах санд регистрийн дугаарын еерчлелтийг нэг бйрчлэн оруулна.

Еерчлөлт оруулах сангийн нэр:

- ХААТР-ийн нэгдсэн сан	/ХААТР-1/
- терсний бүртгэлийн сан	/ИУБ-11/
- їрчилсний бїртгэлийн сан	/ИУБ-12/
- овог, эцэг /эх/-ийн нэр, нэр єерчилсний бїртгэлийн сан	/ИУБ-13/
- эцэг тогтоосны бїртгэлийн сан	/ИУБ-14/
- гэрлэсний бїртгэлийн сан	/ИУБ-15/
- гэрлэлт цуцуулсны бїртгэлийн сан	/ИУБ-16/
- гэрлэлт сэргээсний бїртгэлийн сан	/ИУБ-15/
- нас барсны бїртгэлийн сан	/ИУБ-18/
- иргэний їнэмлэх /паспорт/ шинээр болон дахин олголтын сан	/ИУБ-21/
- шилжилт хөдөлгөөний бїртгэлийн сан	/ИУБ-22/
- регистрийн дугаар єерчлелтийн бїртгэлийн сан	/ХААТР-25/

7.4 Регистрийн дугаар, нөхөн бүртгэл, засвар өөрчлөлт хариуцсан улсын бүртгэгч иргэний регистрийн дугаарын өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, иргэний улсын бүртгэлийн маягтад регистрийн дугаар өөрчилсөн тухай тэмдэглэл хийж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний баримтын архивт маягтыг зохих журмын дагуу /мэдээ хїлээлцэх дэвтэрт бичиж, хїлээлгэн өгсөн тухай гарын їсэг зуруулна/ хїлээлгэн өгнө.

7.5. Иргэний регистрийн дугаар өөрчилсөн тухай маягт /ХААТР-25/-ыг иргэний хувийн хэрэгт хавсаргах ажлыг иргэний баримтын архив хариуцан гүйцэтгэнэ.

8. Регистрийн дугаар олгох ажиллагаанд

тавих хяналт

8.1. Регистрийн дугаар шинээр олгох, өөрчилж дахин олгох, хүчингүй болгоход нийслэлд Бүртгэлийн хяналтын болон Иргэний бүртгэлийн газар, аймагт Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч хяналт тавина.

9. Хариуцлага

9.1. Энэхүү журмыг зөрчсөн улсын бүртгэгч, бүртгэлийн ажилтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

--- оОо ---